ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Төрийн Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа

Утас: 90088028

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: tuul9565@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
4.1 Ерөнхий зүйл ....13
4.2 Материаллаг байдал ....14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл
**16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.01.28 № 37

танай ______ -ны № ______ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ГЭРЭЛТ-ОД -д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогоор 1,948.9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлогоор 313.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 58.0 сая төгрөг нийт 2,320.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлээгүй байхад 1.6 сая төгрөгийн албан томилолтын зардлыг олгосон зөрчил илэрлээ.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага 8.8 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудсыг дутуу хөтөлсөн зөрчил илэрлээ.

D/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

0130 0 32

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 92,876,447.84 | 221,409,498.26 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 0.00 | 127,414,013.42 |
| 8 | Банканд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 127,414,013.42 |
| 9 | Төгрөг | 0.00 | 127,414,013.42 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 127,414,013.42 |
| 14 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | 0.00 |
| 27 | АВЛАГА | 122,487.86 | 15,855,584.86 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 122,487.86 | 15,855,584.86 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 92,753,959.98 | 78,139,899.98 |
| 61 | Түүхий эд материал | 3,295,000.00 | 3,295,000.00 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 3,295,000.00 | 3,295,000.00 |
| 66 | Хангамжийн материал | 89,458,959.98 | 74,844,899.98 |
| 67 | Бичиг хэргийн материал | 3,323,000.00 | 4,033,300.00 |
| 68 | Аж ахуйн материал | 47,686,339.98 | 27,281,299.98 |
| 72 | Хүнсний материал | 4,335,000.00 | - |
| 73 | Бусад хангамжийн материал | 34,114,620.00 | 43,530,300.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,936,998,408.16 | 4,782,862,744.57 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,936,998,408.16 | 4,782,862,744.57 |
| 108 | Биет хөрөнгө | 4,591,508,908.16 | 4,437,373,244.57 |
| 109 | Барилга, байгууламж | 5,321,755,965.65 | 5,321,755,965.65 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (884,440,129.68) | (1,000,584,145.56 ) |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 182,728,920.00 | 182,728,920.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (174,299,605.83) | (182,728,920.00) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 579,776,155.33 | 581,866,155.33 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (454,729,367.50) | (470,741,149.48) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 171,141,749.30 | 171,141,749.30 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (154,035,169.11) | (170,005,720.67) |
| 125 | Номын фонд | 3,610,390.00 | 3,940,390.00 |
| 126 | Биет бус хөрөнгө | 345,489,500.00 | 345,489,500.00 |
| 127 | Программ хангамж | 15,310,000.00 | 15,310,000.00 |
| 128 | Хасагдуулаг | (15,310,000.00) | (15,310,000.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 345,489,500.00 | 345,489,500.00 |
| 138 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 5,029,874,856.00 | 5,004,272,242.83 |
| 139 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 18,934,176.98 | 20,118,914.00 |
| 140 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 18,934,176.98 | 20,118,914.00 |
| 165 | Өглөг | 18,934,176.98 | 20,118,914.00 |
| 166 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 362,234.98 | - |
| 167 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 18,571,942.00 | 20,118,914.00 |
| 215 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 5,010,940,679.02 | 4,984,153,328.83 |
| 216 | Засгийн газрын хувь оролцоо | 5,010,940,679.02 | 4,984,153,328.83 |

| | | | |
|---|---|---|---|
| 217 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 4,844,058,313.76 | 4,844,058,313.76 |
| 218 | Өмч: -Төрийн өмч | 4,844,058,313.76 | 4,844,058,313.76 |
| 224 | Хуримтлагдсан үр дүн | (50,724,641.10) | (77,511,991.29) |
| 225 | Өмнөх үеийн үр дүн | (50,724,641.10) | (50,724,641.10) |
| 226 | Тайлант үеийн үр дүн | - | (26,787,350.19) |
| 228 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 217,607,006.36 | 217,607,006.36 |
| 232 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 5,029,874,856.00 | 5,004,272,242.83 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс ны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,818,829,636.00 | 2,326,178,170.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 102,458,336.00 | 6,120,000.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 102,458,336.00 | 6,120,000.00 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 102,458,336.00 | 6,120,000.00 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,494,300 |
| 83 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,440,000.00 | - |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 101,018,336.00 | 6,120,000.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,710,371,300.00 | 2,320,058,170.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,431,128,800.00 | 1,947,136,400 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,431,128,800.00 | 1,947,136,400 |
| 120 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 6,000,000.00 | - |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 279,242,500.00 | 371,427,470.00 |
| 125 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 264,367,500.00 | 313,403,200.00 |
| 127 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,875,000.00 | 58,024,270.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 1,863,434,991.29 | 2,352,965,520.19 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,776,497,493.20 | 2,193,667,867.59 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,776,497,493.20 | 2,193,667,867.59 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,008,135,794.24 | 1,223,772,343.60 |
| 151 | Цалин | 659,742,536.05 | 723,329,491.92 |
| 152 | Нэмэгдэл цалин | 139,352,715.19 | 392,275,999.51 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 107,736,000.00 | 57,900,000.00 |
| 154 | Урамшуулал | 101,304,543.00 | 50,266,852.17 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 127,123,064.21 | 150,259,903.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 86,890,007.59 | 97,142,202.10 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 10,222,430.70 | 13,279,400.90 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,116,344.49 | 6,639,700.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,971,140.42 | 6,639,700.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 19,923,141.01 | 26,558,900.00 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 282,939,441.91 | 308,813,319.40 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 13,127,641.91 | 10,546,169.40 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 255,126,300.00 | 280,404,150.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 14,685,500.00 | 15,783,000.00 |
| 168 | Байрны түрээс | - | 2,080,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 24,074,459.75 | 36,052,682.00 |
| 171 | Бичиг хэргийн материал | 3,118,943.00 | - |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 3,491,186.00 | 3,914,212.00 |
| 173 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 2,222,720.75 | - |
| 174 | Ном, хэвлэлийн зардал | 281,760.00 | - |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,152,600.00 | - |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 13,807,250.00 | 32,138,470.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 181 | Нормативд зардал | 62,347,370.00 | 64,241,900.00 |
| 182 | Эм | 2,531,350.00 | - |
| 183 | Хоол | 53,908,420.00 | 64,241,900.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,907,600.00 | - |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 23,907,300.00 | 14,685,900.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 10,791,600.00 | 11,808,900.00 |
| 189 | Урсгал засвар | 13,115,700.00 | 2,877,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 2,590,700.00 | - |
| 192 | Дотоод томилолтын зардал | 2,590,700.00 | - |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 9,500,658.00 | 7,800,000.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,375,600.00 | 7,800,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,727,600.00 | - |
| 197 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 397,458.00 | - |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 235,878,705.09 | 388,041,819.59 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 130,934,798.00 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 76,541,250.00 | 100,551,358.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 159,337,455.09 | 156,555,663.59 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 86,937,498.09 | 159,297,652.60 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 63,083,600.00 | 153,957,800.00 |
| 234 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,472,900.00 | 30,695,500.00 |
| 235 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 54,906,700.00 | 118,268,000.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 704,000.00 | 4,994,300.00 |
| 237 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 23,853,898.00 | - |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,853,898.00 | - |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.09 | 5,339,852.60 |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.09 | 5,339,852.60 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (44,605,355.29) | (26,787,350.19) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | (44,605,355.29) | (26,787,350.19) |

## 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,717,811,300.00 | 2,320,058,170.00 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,440,000.00 | - |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 1,440,000.00 | - |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,440,000.00 | - |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,494,300 |
| 84 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,440,000.00 | - |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,716,371,300.00 | 2,320,058,170.00 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,431,128,800.00 | 1,947,136,400 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,431,128,800.00 | 1,947,136,400 |
| 119 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 6,000,000.00 | - |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 279,242,500.00 | 371,427,470.00 |
| 124 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 264,367,500.00 | 313,403,200.00 |
| 126 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,875,000.00 | 58,024,270.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 1,699,676,410.00 | 2,190,224,156.58 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,699,676,410.00 | 2,190,224,156.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,612,738,911.91 | 2,030,926,503.98 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,000,966,370.27 | 1,224,134,578.58 |
| 151 | Үндсэн цалин | 552,485,399.86 | 723,329,491.92 |
| 152 | Нэмэгдэл | 247,994,899.19 | 392,638,234.49 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 107,889,071.45 | 57,900,000.00 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 92,596,999.77 | 50,266,852.17 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 133,981,954.00 | 165,993,000.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 91,135,237.76 | 112,875,300.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 10,626,358.14 | 13,279,400.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,612,546.51 | 6,639,700.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 2,140,469.23 | 6,639,700.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 21,467,342.36 | 26,558,900.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 264,367,499.91 | 307,266,347.40 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 13,127,641.91 | 10,546,169.40 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 236,554,358.00 | 277,909,800.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 14,685,500.00 | 16,730,378.00 |
| 168 | Байрны түрээс | - | 2,080,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 24,074,459.75 | 3,914,270.00 |
| 171 | Бичиг хэрэг | 3,118,943.00 | - |
| 172 | Тээвэр, шатахуун | 3,491,186.00 | 3,914,270.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,222,720.75 | - |
| 174 | Ном, хэвлэл | 281,760.00 | - |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,152,600.00 | - |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,807,250.00 | - |
| 181 | Нормативд зардал | 59,047,370.00 | 64,241,900.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,531,350.00 | - |
| 183 | Хоол, хүнс | 50,608,420.00 | 64,241,900.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,907,600.00 | - |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,209,400.00 | 17,397,400.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 3,051,100.00 | - |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 10,791,600.00 | 14,520,400.00 |
| 189 | Урсгал засвар | 13,366,700.00 | 2,877,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 2,590,700.00 | - |
| 192 | Дотоод албан томилолт | 2,590,700.00 | - |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,500,658.00 | 7,800,000.00 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 7,375,600.00 | 7,800,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,727,600.00 | - |
| 197 | Даатгалын үйлчилгээ | 397,458.00 | - |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,000,499.98 | 240,179,008.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 139,450,100.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 91,000,499.98 | 100,728,908.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 86,937,498.09 | 159,297,652.60 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 63,083,600.00 | 153,957,800.00 |
| 231 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,472,900.00 | 30,695,500.00 |
| 232 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 54,906,700.00 | 118,268,000.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 704,000.00 | 4,994,300.00 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 23,853,898.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,853,898.00 | - |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.09 | 5,339,852.60 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.09 | 5,339,852.60 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 18,134,890.00 | 129,834,013.42 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 18,134,890.00 | 2,420,000.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 18,134,890.00 | 2,420,000.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 18,134,890.00 | 2,420,000.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,134,890.00 | 2,420,000.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (18,134,890.00) | (2,420,000.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 127,414,013.42 |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 127,414,013.42 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,844,058,313.76 | 217,607,006.36 | -50,724,641.10 | 5,010,940,679.02 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,844,058,313.76 | 217,607,006.36 | -50,724,641.10 | 5,010,940,679.02 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,844,058,313.76 | 217,607,006.36 | -50,724,641.10 | 5,010,940,679.02 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.0 | 0.0 | -26,787,350.19 | -26,787,350.19 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,844,058,313.76 | 217,607,006.36 | -77,511,991.29 | 4,984,153,328.83 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,320,058,170.00 | 2,187,304,303.98 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,320,058,170.00 | 2,187,304,303.98 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 2,166,100,370.00 | 2,033,346,503.98 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,327,944,900.00 | 1,224,134,578.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Үндсэн цалин | 781,375,600.00 | 723,329,491.92 |
| 7 | Нэмэгдэл | 491,534,500.00 | 392,638,234.49 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 55,034,800.00 | 57,900,000.00 |
| 9 | Урамшуулал | - | 50,266,852.17 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 165,993,000.00 | 165,993,000.00 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 112,875,300.00 | 112,875,300.00 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 13,279,400.00 | 13,279,400.00 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 6,639,700.00 | 6,639,700.00 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 6,639,700.00 | 6,639,700.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 26,558,900.00 | 26,558,900.00 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 312,562,700.00 | 307,266,347.40 |
| 18 | Гэрэл цахилгаан | 15,841,900.00 | 10,546,169.40 |
| 19 | Түлш, халаалт | 277,909,800.00 | 277,909,800.00 |
| 20 | Цэвэр, бохир ус | 16,731,000.00 | 16,730,378.00 |
| 21 | Байрны түрээс | 2,080,000.00 | 2,080,000.00 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 3,914,270.00 | 3,914,270.00 |
| 23 | Бичиг хэрэг | - | - |
| 24 | Тээвэр (шатахуун) | 3,914,270.00 | 3,914,270.00 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | - | - |
| 26 | Ном, хэвлэл | - | - |
| 30 | Нормативд зардал | 64,249,500.00 | 64,241,900.00 |
| 32 | Хоол, хүнс | 64,249,500.00 | 64,241,900.00 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | - | - |
| 34 | Эд хогшил худалдан авах | 17,440,900.00 | 17,397,400.00 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 14,520,400.00 | 14,520,400.00 |
| 38 | Урсгал засвар | 2,920,500.00 | 2,877,000.00 |
| 39 | Томилолт, зочны зардал | - | - |
| 41 | Дотоод албан томилолт | - | - |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,800,000.00 | 7,800,000.00 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,800,000.00 | 7,800,000.00 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | - |
| 46 | Даатгалын үйлчилгээ | - | - |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | - | - |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | - | - |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 266,195,100.00 | 242,599,008.00 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,780,100.00 | 139,780,100.00 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 126,415,000.00 | 102,818,908.00 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 153,957,800.00 | 153,957,800.00 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 153,957,800.00 | 153,957,800.00 |
| 76 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,695,500.00 | 30,695,500.00 |
| 77 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 118,268,000.00 | 118,268,000.00 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 4,994,300.00 | 4,994,300.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 313,403,200.00 | 2,320,058,170.00 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 1,948,630,700.00 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | - | 1,948,630,700.00 |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 313,403,200.00 | 371,427,470.00 |
| 123 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын | 313,403,200.00 | 313,403,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 125 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 58,024,270.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 56.00 | 56.00 |
| 134 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 37.00 | 37.00 |

**2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 366,088.05 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 366,088.05 |
| 3 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 366,088.05 |
| 4 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 307,266.35 |
| 5 | Гэрэл цахилгаан | 10,546.17 |
| 6 | Түлш халаалт | 277,909.80 |
| 7 | Цэвэр бохир ус | 16,730.38 |
| 8 | Байрны түрээс | 2,080.00 |
| 9 | Хангамж, бараа материалын зардал | 3,914.27 |
| 10 | Тээвэр, шатахуун | 3,914.27 |
| 11 | Урсгал засварын зардал | 2,877.43 |
| 12 | Нормативд зардал | 9,467.50 |
| 13 | Хоол, хүнс | 9,467.50 |
| 14 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,800.00 |
| 15 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 7,800.00 |
| 16 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,762.50 |
| 17 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,762.50 |
| 18 | Урсгал шилжүүлэг | 5,339.85 |
| 19 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 371,427.90 |
| 20 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 313,403.20 |
| 21 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 58,024.70 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Завхан аймаг Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн зорилго:*** Суралцагчдын төлөвшил, ур чадварыг хөгжүүлэгч сургууль болох

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.6 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Завхан аймаг Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрдөг хууль:***

1. Мэргэжлийн боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий тухай хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд төрийн сангийн мэргэжилтэн хяналтыг хийж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймаг Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймаг Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 25,602.66 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0 | 127,414.00 | (127,414.00) |
| Авлага | 122.48 | 15,855.50 | (15,733.02) |
| Бараа материал | 92,753.90 | 78,139.80 | 14,614.10 |
| Үндсэн хөрөнгө | 4,936,998.40 | 4,782,862.70 | 154,135.70 |
| Нийт хөрөнгө | 5,029,874.86 | 5,004,272.20 | 25,602.66 |
| Өглөг | 18,934.20 | 20,118.90 | (1,184.70) |
| Засгийн газрын хувь оролцоо | 5,010,940.68 | 4,984,153.33 | 26,787.35 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 5,029,874.86 | 5,004,272.20 | 25,602.66 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 127,414.0 мянган төгрөгөөр өссөн нь зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын эхний үлдэгдэл 122.48 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 15,733.09 мянган төгрөгийн авлага нэмэгдэж эцсийн үлдэгдэл 15,855.5 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 92,753.9 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 217,606.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 6,120.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 238,340.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 78,139.8 мянган төгрөг болж өмнөх оноос 14,614.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 2,420.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, элэгдэл тооцсоноор жилийн эцэст 4,782,862.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй болж 154,135.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны элэгдлийн зардалд 156,555.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Өглөгийн дансны хувьд 1,184.7 мянган төгрөгөөр өссөн байна.
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч 153,016.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,948,630.7 мянган төгрөг, нийт зарлагыг 1,948,630.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,947,136.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,494.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,821,216.6 мянган төгрөг буюу 93.4 хувьтай байна. Энэ нь үндсэн цалин 58,046.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 69,367.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71804** | **Мэргэжлийн Боловсрол** | | | | |
| 80802 | Ажил олгогчоос тэтгэмж | 152,463.5 | 152,463.5 | - | 100% |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 54,782.0 | 54,774.4 | 7.6 | 100% |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр | 1,327,944.9 | 1,200,538.5 | 127,406.4 | 92.2% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 84,777.1 | 84,777.1 | - | 100% |
| | **НИЙТ** | **1,948,630.7** | **1,821,216.6** | **127,414.0** | **93.4%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвөөс 313,403.2 мянган төгрөгийн, өөрийн орлогоор 58,024.3 мянган төгрөгийн, нийт 317,427.4 орлого төвлөрүүлсэн байна. Тус орлогоос 307,266.3 мянган төгрөгийг тогтмол зардалд, 9,467.5 мянган төгрөгийг хоолны зардалд, 7,800.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд, 3,914.3 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 2,877.4 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 34,762.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулж хэмнэгдсэн 5,339.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| | Шууд гэрээ байгуулах | Хоол хүнс | 64,241.9 | 64,241.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Шууд гэрээ байгуулах | Хөрөнгө худалдан авах | 2,420.0 | 2,420.0 |
| | **Нийт дүн** | | **66,661.9** | **66,661.9** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа , аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр 02 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,352,965.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 35,294.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл суман дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 42,953.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 4 | 42,953.8 | 4 | 42,953.8 | 100% |
| Зөвлөмж | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | **4** | **42,953.8** | **4** | **42,953.8** | **100%** |

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 52,255.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн бөгөөд 41,740.9 мянган төгрөгийн хоолны зардал, суралцагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардлын гүйцэтгэлийн баримтыг дутуу хавсаргасан алдааг залруулан, 8,861.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж 1,652.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

## 5.1 Төлбөрийн акт

Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр 1,652.6 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

### 5.3 Зөвлөмж

*Илрүүлэлт:*

1. Жолоочийн тооцооны хуудасгүй, тооцоо бодсон баримтгүйгээр 8,861.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

*Өгсөн зөвлөмж*

- Шатахууны зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулан, жолоочийн тооцооны хуудсыг тогтмол хөтлөх, шатахууны тооцоог холбогдох журмын дагуу хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хүнсний материал зарлагадахдаа технологийн карт, тайлан бүрэн гаргаагүй. | 1 | 27,220.4 | | | 1 | 27,220.4 | 1 | 27,220.4 | | | | |
| хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зардлын гүйцэтгэлийн баримтыг дутуу хавсаргасан | 1 | 14,520.4 | | | 1 | 14,520.4 | 1 | 14,520.4 | | | | |
| **Дүн** | **2** | **41,740.9** | | | **2** | **41,740.9** | **2** | **41,740.9** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жолоочийн тооцооны хуудасгүй, тооцоо бодсон баримтгүйгээр шатахуун зарцуулсан | 1 | 8,861.8 | | | | | 1 | 8,861.8 | | | | |
| Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр албан томилолтын зардал олгосон | 1 | 1,652.6 | 1 | 1,652.6 | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **10,514.4** | **1** | **1,652.6** | | | **1** | **8,861.8** | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

**ХЯНАСАН :**

| | |
|---|---|
| ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Д.БАТ-УНДРАА |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Х.БОЛДБААТАР |
| АХЛАХ АУДИТОР | Г.ЗАЯА |

**БОЛОВСРУУЛСАН :**

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ

ОГНОО: 2025-02-22